


Касс дээр тасалбар бичээд хэвлэх команд өгсөн бол тухайн тасалбар хэвлэгдэж гараагүй ч гэсэн тухайн тасалбар дээрх бараанууд борлуулалтын тайландаа хадгалагдаж үлдэгдлээс хасагдах болно. Тухайн тасалбар хадгалагдсан эсэхийг програм дээр шалгахдаа **Тайлан -> Тасалбар** цэсийг сонгож хэвлэсэн тасалбарыг огноо болон тасалбарын дугаараар шүүж харах боломжтой.



Тасалбарыг тасалбарын дугаараар шүүж харахдаа **Огноо** баганы ард байрлах **Дугаар** баганад байх дугаараар тухайн тасалбарыг шүүнэ. Тасалбарыг дахин хэвлэх тохолдолд Ctrl + F12 командаар хамгийн сүүлд бичигдсэн тасалбарыг дахин хэвлэх боломжтой. Дахин хэвлэгдсэн тасалбар нь 2D код буюу QR кодгүй хэвлэгдэнэ. Зөвхөн хамгийн сүүлд бичигдсэн тасалбарыг л дахин хэвлэх боломжтой гэдгийг анхаарна уу.

